



## БАЙГАЛИЙН ШИНЖЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

213500 Ховд аймаг Утас: (77006905)  
E-mail: khu@khu.edu.mn

2022.09.09 № 01

Хичээлийн тодорхойлолт хүргүүлэх тухай

### МУИС, ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, ОЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ТЭНХИМИЙН БАГШ, ДЭД.ПРОФ. Н.ОЮУНЧИМЭГ ТАНАА

Монгол улсын их сургууль, Шинжлэх ухааны их сургууль, Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхимийн 2022-2023 оны хичээлийн жилд “Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” хичээлийг МУИС-ын сургалтын журмын дагуу шинээр болон шинэчлэн боловсруулж байгаа хичээлийн хөтөлбөрийн талаар түншлэгч байгууллага болох Ховд их сургууль нь дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

“Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” хичээлийн агуулгын хүрээнд байгаль хамгааллын үндсэн онол, арга хэрэгслийн талаар суурь мэдлэг эзэмшүүлэхийн зэрэгцээ байгаль орчинд учирч буй аюул дарамтыг үнэлэх, байгаль хамгааллын төлөвлөлтийн аргазүй, MIRADI, METT-Management effectiveness tracking tool зэрэг програм хангамжийг ашиглах чадвар, дадлыг олгож байгаа нь судлаачдын эрэлт хэрэгцээнд нийцэж байна.

Сургалтад MIRADI, METT-Management effectiveness tracking tool зэрэг програм хангамжийг ашиглан тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, байгаль орчинд үүсэж буй аюул заналыг үнэлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох арга зүй эзэмшүүлж байгаа нь чадварлаг мэргэжилтэн, судлаач бэлтгэх бололцоо нөхцөлийг хангаж байна.

“Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” хичээлийн агуулга, хөтөлбөртэй дэлгэрэнгүй танилцаж үзээд докторын сургалтын төлөвлөгөөнд сонгон судлах хичээлийн хүрээнд үзэж судалж байгааг дэмжиж байна.

#### Хөтөлбөрт өгөх саналууд.

1. Хог хаягдлын менежмент гэсэн агуулгын хүрээнд хогийг ангилан ялгах, дахин боловсруулан ашиглах олон улсын туршлага, технологи, практикт хэрэгжүүлсэн арга замын талаар мэдээ материалыг түлхүү оруулах
2. Монгол орны ойн дагалт нөөцийг зохистой ашиглах, хамгаалах талаар технологийн оновчтой шийдлүүдийг нэмж оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Санал бичсэн:

Ховд их сургуулийн химийн тэнхимийн багш, дэд проф *А. Амаржаргал* А.Амаржаргал

